



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 06 сарын 04 өдөр

Дугаар 261

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Оюуны өмчийн газрын албан ажлын хэрэгцээнд зориулан өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр 160,000,000.00 (нэг зуун жаран сая) төгрөгт багтаан 2 ширхэг автомашин худалдан авахыг зөвшөөрч, худалдан авах автомашины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга А.Билгүүн, Оюуны өмчийн газрын дарга Э.Эрдэнэсүрэнд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНБАТ


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



0000493

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 06 дугаар сарын 04 ны өдрийн
267 дугаар тогтоолын хавсралт



ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН ХУДАЛДАН АВАХ АВТОМАШИНЫ
ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ҮНИЙН ДЭЭД ХЯЗГААР

Д/д	Автомашины техникийн үзүүлэлт	Тоо шир хэг	Худалдаж авах хөрөнгийн үнийн дээд хязгаар (төгрөг)	
			Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Суудлын тоо 12, хөдөлгүүрийн багтаамж	1	81,000,000.00	81,000,000.00
2	Суудлын тоо 5, хөдөлгүүрийн багтаамж	1	79,000,000.00	79,000,000.00
	Нийт дүн			160,000,000.00 (нэг зуун жаран сая)